

# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.22 №37 (37)

ҮЙЛ ЯВДАЛ

## ХАЛАГДАХ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЛЭЭ

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг нар Зэвсэгт хүчний 032 дугаар ангид 2020 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан алба хаагаад удахгүй халагдах гэж байгаа алба хаагчидтай уулзан албаа нэр төртэй хаасан явдалд талархал дэвшүүлээ.

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг эхлээд тус ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаярын ангийн бэлэн байдал, бэлтгэлжилтийг дээшлүүлэх хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цэргийн сургалт, сэтгэл зүйн бэлтгэл, энхийг дэмжих болон бүтээн байгуулалт дахь оролцооны талаарх мэдээллийг сонсож, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудал байгааг тодруулав. Үүний дараа тэрээр Хүндэт харуулын тусгай рот, Харуул үйлчилгээний тусгай ротын цэргийн байр, Эрүүл мэндийн төвөөр орж, хугацаат цэргийн алба хаагчдын ар тал, хангалт, засвар үйлчилгээний байдалтай танилцсан юм.



Үүний дараа дайчидтай уулзан цэргийн албаа нэр төртэй, үлгэр жишээчээр хаасан дэд түрүүч Ц.Үржинханд, байлдагч Б.Баттөр, Э.Хүдэрчулуун нарыг ЗХЖШ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнасныг гардуулж баяр хүргээд, цэргийн албаараа үргэлж бахархаж явахыг онцлон захилаа.

### ТОРГОН ЦЭРГҮҮД ГЭДГЭЭРЭЭ ҮРГЭЛЖ БАХАРХАЖ ЯВААРАЙ

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.ГАНЗОРИГ:



-Хугацаат цэргийн алба та бүхэнд хэр их өөрчлөлт авчирсан бэ гэсэн асуултыг хүн бүр хувьдаа бодож үзээрэй. Түүнчлэн ирээдүйд өрх гэрээ авч явах залуучууд та бүхэн амьдралд өөрсдийгөө бэлдэх хэрэгтэй юм шүү. Бүхэл бүтэн айл өрхийн тэргүүн байна гэдэг амаргүй даваа. Та бүхэн эргээд энгийн амьдралдаа орсон хойноо ч цэргийн анд нөхдөө хэзээ ч битгий мартаарай. Өнөөдөр энэ танхимд сууж байгаа хүн бүр өөрсдийн гэсэн үзэл бодолтой. Тэгэхдээ цэргийн албанд сурсан сахилга бат, эр зориг, бусдыг хүндлэх чадвараа хэзээ ч алдаж болохгүй гэдгийг онцгойлон захиж хэлмээр байна.

Дээрээс нь амьдралаа одооноос төлөвлөж сурах хэрэгтэй. Мөн архи, хар тамхинаас үргэлж хол яваарай. Эдгээрээс болж ямар олон асуудлыг үүсгэж болдгийг бид бүгдээрээ мэднэ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд тодорхой хэмжээний эрүүл чийрэг бие бялдар, амьдралын зөв хэвшлийг олж авсан болов уу гэж найдаж байна. Эрүүл мэндээ маш сайн анхаарах хэрэгтэй юм шүү. Хүн гэдэг байгалийн бүтээл бие бялдын асар их нөөцтэй

байдаг. Би АНУ-ын Рейнжерийн дамжааг дүүргэсэн. Хүн сэтгэл санаагаа удирдаж чадвал ямар ч хүнд давааг туулж чаддаг юм байна гэдгийг ойлгосон. Бид 35 нас хүртэлх ачаалал гэдэг зүйлийг айхааргүй давах чадвартай. Харин түүнээс цааш амьдралаас олсон туршлагаараа амьдрах хэрэгтэй.

Цэргийн албанд өнгөрүүлсэн хугацаа маш сайхан дурсамж болж үлддэг. Үүгээрээ ирээдүйн амьдралын нугачаан дунд өөрийгөө хөглөж байгаарай. Монгол төрийн нүүр царай болсон Торгон цэргүүд гэдгээрээ үргэлж бахархаж яваарай. Өнөөдөр монгол цэргүүд дэлхийн цэрэг болж, сансрын уудамд эх орныхоо алдар цууг дуурсгаж чадсан. Ирэх сарын нэгэнд та бүхэн цэргийн албанаас халагдах боловч эргээд Зэвсэгт хүчнийхээ бэлтгэл, нөөцөд шилжинэ. Эр хүн алсын хараатай байх хэрэгтэй. Гаргаж буй шийдвэр чинь зөв үү, буруу юу гэдгийг сайн бодож байгаарай. Асуудалд ухаалгаар хандах хэрэгтэй. Дахин хэлэхэд албаныхаа нэр хүндийг үргэлж өндөрт өргөж яваарай.

### ЦЭРГҮҮДЭЭ ЭХ ОРНОО ХАМГААЛАХ ЧАДВАРТАЙ ЭР ХҮН БОЛГООД ЭЭЖ ААВД НЬ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.МӨНХБАЯР:



-Удахгүй бид хугацаат цэргийн алба хаагчдаа халах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна. Төрийн ёслолын Цагаан туганд хүндэтгэл үзүүлээд нэг жилийн албаа хааж халагддаг учиртай. Хугацаат цэргийн алба хаагчид маань өнгөрсөн нэг

жилийн хугацаанд төрийн болон цэргийн ёслолын үйл ажиллагаанд амжилттай оролцож, харуул, үйлчилгээний тусгай ротын бие бүрэлдэхүүн өөрсдийн үүргээ чадварлагаар гүйцэтгээд ёс төртэй халагдаж байна. Цэргийн албыг хаана гэдэг нь тухайн хүний цаашид биеэ авч явах төлөвшил, хүмүүжил, сэтгэл зүйг нь бэлдээд цаашид улс орондоо хэрэгтэй, аль эсвэл ажиллаж, хөдөлмөрлөх ямар ч орчин нөхцөлд бие даагаад амьдрах чадварыг эзэмшүүлдэг онцлогтой. Цэргүүд янз бүрийн боловсролын түвшинтэй байдаг. Жилийн хугацаанд эдгээр залуусыг төлөвшүүлэх нь цэргийн албаны бас нэг онцлог. Тиймээс нь бид цэргүүдээ эх орноо хамгаалах чадвартай жинхэнэ эр хүн болгоод аав ээжид нь хүлээлгэн өгч байгаа хэрэг юм.

### АМЬДРАЛЫН МИНЬ ГУРВАН ЗОРИЛГЫН НЭГ НЬ ЦЭРГИЙН АЛБА ХААХ БАЙСАН

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн байлдагч Б.ГАНТУЛГА:



-Монгол Улсын өнцөг булан бүрээс шилэгдэж, сонгогдож ирсэн залуучуудтай хамт энэхүү хүндтэй албыг хааснаараа маш их бахархаж байна. Энэ мундаг залуучуудтай нөхөрлөх нь надад том хувь тохиол байлаа. Би багаасаа амьдралдаа гурван зорилго дэвшүүлсний нэг нь цэргийн албыг өөрийн биеэр хаах байсан. Цэргийн албанд ирснээрээ амьдралынхаа жинхэнэ найзуудыг олсон гэж боддог. Зовлон жаргалаа хуваалцаж, бие биенийхээ нууцыг мэдэж, бэлтгэл сургалтыг хамтдаа давсан жинхэнэ эрчүүдийн нөхөрлөл байж чадсан. Цаашид хөгшин буурал болтлоо найзална гэж бодож байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
14	-1

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	23

#### АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
19	4

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.391.00	3.451.00
CNY	436.50	440.90
RUB	36.50	38.00
JPY	26.06	26.56
KRW	2.46	2.60

### ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 10  
2021.04.22.  
/ПҮРЭВ ГАРАГ/

#### ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ДӨРВӨН НОГООН ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ.

Наран ургах, шингэх:

05.50-19.52

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Мунхарахуй

Суудал:

Гал.

Аргын тооллын 4 дүгээр сарын 22, Бархасвадь гараг. Билгийн тооллын 10, Их морь одтой, цагаан хулгана өдөр. Өдрийн наран 5 цаг 50 минутад мандан, 19 цаг 52 минутад жаргана. Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, лусыг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдах, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

#### НИЙТ БҮРТГЭГДСЭН

24.195+1169

#### ЭДГЭРСЭН

13.346

#### НАС БАРСАН

56/6

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

#### НИЙТ БАТЛАГДСАН

1812 (13)

#### ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

308

#### ЭДГЭРСЭН

1490

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

#### Тохиолдол

Нийт: 141,754,944

#### Эдгэрсэн

Нийт: 115,472,673

#### Нас барсан

Нийт: 3,025,835

#### ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

6,609 644,024

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ/НГУ/ НИЙТ

15,005 2,592,363

ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

1,980 363,172

ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

456 63,240

2021.04.21

11:00 ЦАХИМ БАЙДАГ



ҮЙЛ ЯВДАЛ

ХАЛАГДАХ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЛЭЭ

(Түрүүч нь I нүүрт)

ЦЭРГИЙН ЭРДЭМ ЦААШДЫН АМЬДРАЛД МИНЬ ИЛҮҮ ТОДОРЧ ГАРЧ ИРНЭ ГЭЖ ХАРЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн байлдагч Б.ХАНГАЙБАЗАР:

-Би "MIU" олон улсын дээд сургуулийн хоёрдугаар дамжааны оюутан байхдаа цэргийн албанд татагдсан. Олон аавын хүүгийн хаадаг албыг би ч гэсэн яагаад хааж болдоггүй юм гэж өөрийгөө хурцалж, энэ хүндтэй албанд татагдсан. Анх бид цэргийн анхан шатны бэлтгэлд хамрагдахаас эхлээд мэдээжийн хэрэг тун өөр орчин утгсан. Миний төрсөн ах цэргийн хүн. Эргэн тойрон дүүрэн цэргийн эрээн хувцастай хүмүүсийг хараад ахыгаа их санаж билээ. Ингээд бодоход их л дурсамжтай цаг хугацаа байж дээ. Өнгөрсөн жил орчмын хугацаанд олон сайхан залуучуудтай жаргал, зовлонгоо хуваалцах сайхан байлаа. Халагдахад тун бага хугацаа үлджээ. Өөр хүн халагдах гэж байгаа юм шиг нэг л итгэж өгөхгүй байна. Цэргийн алба хааснаараа хувь хүний хүмүүжил, тэсвэр тэвчээр, хатуужил гээд олон зүйлийг олж авснаас гадна Хүндэт харуулын ангид алба хааснаараа бахархах болсон. Төрийн, цэргийн ёслолд олон удаа оролцсон. Аав ээж, найз нөхдөдөө ярих зүйлтэй, дүүрэн дурсамжтай үлдсэндээ баяртай байна. Хүмүүс цэргийн албанд олон зүйлийг сурсан гэж ярьдаг. Тэр бүгд үнэн юм байна гэдгийг ойлгосон. Миний хувьд цэргийн албанаас сурсан зүйлс их ч гэсэн хамгийн гол нь энэ нь цаашдын амьдралд илүү тодорч гарч ирнэ гэж харж байна. Энэ албаараа би үргэлж бахархах болно.



ЦЭРГИЙН АЛБАНААС МАШ ОЛОН ЗҮЙЛИЙГ СУРСАН

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн байлдагч П.БАТТӨР:

-Би 2020 оны нэгдүгээр ээлжээр Дорнод аймгаас цэргийн албанд татагдсан, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн мэдээллийн технологийн инженерийн ангийн хоёрдугаар дамжааны оюутан. Өнгөрсөн жил цар тахлаас үүдэн улс даяараа цахим байдлаар хичээллэсэн энэ цаг хугацааг ашиглаад цэргийн алба хааж, цаг хожьд гэж шийдсэн. Цэргийн алба миний төсөөлснөөс өөр байсан. Маш олон зүйлийг сурч болдог гэдгийг ойлгосон. Би нэг зүйлийг онцолж хэлмээр байна. Энэ бол нэг нь нийтийн төлөө нийт нь нэгийн төлөө буюу нөхөрлөл юм. Аав, ээж минь намайг цэрэгт явахад ихийг сураад ирээрэй гэж захисан. Энэ захиасыг нь биелүүлсэн гэдэгтээ итгэлтэй байна. Мөн өнгөрсөн хугацаанд цэргээс халагдсаныхаа дараа яах талаараа олон зүйлийг төлөвлөсөн.

МЭРГЭЖИЛТНҮҮД ЗӨВЛӨЖ БАЙНА

ХӨГЖҮҮЛЭХ ШАТНЫ СУРГАЛТЫГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу үндсэн салбарын жигдрэлтийн шатны сургалт, бэлтгэл амжилттай зохион байгуулагдаж нэгтгэл, ангиудын төгсгөлийн шалгалт явагдаж дууссан.

Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 5 дугаар сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хөгжүүлэх шатны сургалт зохион байгуулагдана. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги /байгууллага/, салбарууд хөгжүүлэх сургалтыг бие бүрэлдэхүүний боловсролын түвшин, алба хаасан хугацаа болон мэдлэг, дадлага, ур чадвартай нь уялдуулан цэргийн алба хаагчдын бие даан өөрийгөө хөгжүүлэх, албан бус сургалтад хамрагдах болон ажлын байранд тавигдах шаардлагыг хангахад чиглүүлэн мэргэжлийн суурь хичээл, албан бус болон мэргэжил олгох сургалт, ажлын байрны анхан шатны сургалтуудаар дараах байдлаар явуулна. Үүнд:

1.Мэргэжлийн суурь хичээлүүдийг ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсээс боловсруулан ЗХЖШ-ын даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад явагдах мэргэжлийн суурь хичээлийн нэгдсэн хөтөлбөр"-ийн дагуу бие даалтаар судлуулах;

2.Тухайн нэгтгэл, ангийн захирагчийн тушаалаар цэргийн албаны хэрэгцээ, шаардлага, цэргийн алба хаагчдын сонирхол, нэгтгэл, анги, байгууллагын материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүний боломжид нийцүүлэн төрөл бүрийн секц, дугуйланг хичээллүүлэх, төрөл мэргэжлийн цугларалт, семинар явуулах, онлайн (цахим) курс, дамжаанд хамруулах;

3.Офицер, ахлагч нарын бие даан гүйцэтгэх ажлыг сургуулийн жилд судалсан

хичээлийн хөтөлбөрийн агуулга болон дээд шатны байгууллагаас тогтоосон даалгаврын жагсаалттай уялдуулан эсээ, ангийн ажил бичүүлж хамгаалуулах;

4.Албан бус болон мэргэжил олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран зохион байгуулах;

5.Ажлын байрны анхан шатны сургалтыг сургууль, дамжаа төгссөн болон албан тушаалд шинээр томилогдсон бүрэлдэхүүнийг өөрийн ажлын байранд нь сурган дадлагажуулах зорилгоор ЗХЖШ-ын даргын 2017 оны А/257 дугаар тушаалаар батлагдсан "Ажлын байрны анхан шатны сургалтын хөтөлбөр"-ийн дагуу зохион байгуулах;

6.Ирэх сургуулийн жилийн бэлтгэл ажлыг эртнээс хангуулж сургалтын материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх (засварлах, сайжруулах), хичээл заах үндсэн болон туслах бүрэлдэхүүнийг ангийн захирагчийн тушаалаар томилгоожуулж заах арга зүйг нь дээшлүүлэх, бүх төрлийн лекц, конспект, төлөвлөгөөнд баяжилт хийж салаа, салбарын офицерууд лекц, конспект, төлөвлөгөөг гар бичмэлээр боловсруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн бие бүрэлдэхүүнийхээ эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилгоор сургалт, дадлагыг тогтмол явуулах. Үүний тулд офицер, ахлагч нарт тэдний бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинд нийцүүлэн биеийн тамирыг бэлтгэл хэлбэрээр, хугацаат цэргийн алба хаагчдад сургалт-хичээл хэлбэрээр, ажилтан, албан хаагчдад бие даан хөгжүүлэх хэлбэрээр хуваарь (тогтсон өдөр, цаг), төлөвлөгөөг чанд баримтлан зохион байгуулахад анхаарч ажиллана уу.

ЗХЖШ-ын СБЗХ-ийн мэргэжилтэн, дэд хурандаа А.БАТСҮХ

ЦЭРГИЙН ТАНГАРАГ

Цэргийн тангаргийн язгуур утга санааг хэрхэн авч үзэх тухайд зарим тайлбар тольд "Тангараглах-ам алдаж андгалахыг буюу", "Тангараг-батыг үзүүлсэн амалдсан үгийг тангараг хэмээмүй" гэх зэргээр нэгэн адил утгачилан тайлбарласан бол "Монгол хэлний товч тайлбар толь"-д "Андгай тангараг, андгай тангараг хоршой үг", Цэргийн нэр томьёоны тайлбар тольд "Монгол Улсын Зэвсэгт хүчний эгнээнд орсон цэргийн алба хаагч, цэргийн үүрэгтэн бүрийн төрөлх эх орон-Монгол Улс, ард түмэн, төр, засагтаа үнэнч байхаа баталж, баяр ёслолын байдалтай эх орондоо өргөх амлалт" хэмээн тус тус тайлбарлан тэмдэглэжээ.

"Улсын анхдугаар их хурал хуралдсан 1924 оны 11 дүгээр сарын 14-нд Улаанбаатар гарнизоны морин пулемёт бууны тусгай хороо өргөн чөлөөнд цугларч, Улсын Их Хурлын төлөөлөгчдөд баяр хүргээд, 10 зүйлтэй тангараг өргөжээ. БНМАУ-ыг батлан хамгаалахад бэлэн гэж цэргийн алба хаагчид эх орон, ард түмэндээ анх удаа тангараг өргөсөн нь цаг хугацааны хувьд Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэн дэх Ардын цэргийн анхны тангараг болсон нь энэ юм. Харин МАХЦ-ийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүн 1925 оноос эхлэн цэргийн алба хаагчид нэг бүрчлэн тангараг өргөхдөө Монголын Ардын хувьсгалын ялалтын баярын өдөр 7 дугаар сарын 11-нд Зэвсэгт хүчний жанжин, цэргийн яамны сайд /хязгаарын нэгтгэл, ангид бол түүний дарга/ уул тангарагийг уншиж, бусад нь дагалдан хэлдэг" байжээ. Үүнд: "Ардын улаан цэргийн наадмын газар ардын улаан цэргээр тангараглах нь:

Нэг. БНМАУ-ын харьяат цэрэг би жинхэнэ ардын үндсэн мөн болох тул бүх Монголын хувьсгалт улаан цэргийн нэр тушаалыг дуртайяа сүслэн хүлээхгүй илтгэнэ.

Хоёр. Цэрэг би эрдэм сургуулийг боловсруулан эрх чөлөөг нийгэм олгуулахыг нотод хүлээнэ. Энэхүү хүлээсэн нэр тушаалыг чин үнэн санаанаас хадгалан

гүйцэтгэж явахыг илтгэнэ.

Гурав. Ард түмний бие хөрөнгийг аливаа аюулаас туйлын шударга сайнаар хамгаалан сахиж, Ардын засгийн зэрэг газраас гаргасан тушаалыг хууль ёсоор шууд журамлан гүйцэтгэхийг илтгэнэ.

Дөрөв. Улсын харьяат цэрэг ардын нэр сүрд гажууг өдүүлэхгүй явдлыг үрдаас болгоомжлон биеийг залруулан тэвчиж, бусдыг удирдан бүгдээрийн хүчийг нэгтгэж, жинхэнэ ард түмний бүрэн эрх чөлөө мандуулах их хэрэгт зориулахыг илтгэнэ.

Тав. Ардын цэргийн амь хөрөнгийг хайрлахгүй зүтгэн байгуулсан Ардын засгийн аливаа хэрэг, явдлыг гажуудуулах гадаад, дотоодын дайсан гарах аваас ардын цэрэг би амь биеийг хайрлахгүй аюулт дайсныг устгаж, амгалангийн эрх чөлөөг хамгаалахыг илтгэнэ.

Зургаа. Цэрэг би эл илтгэсний ёсоор гүйцэтгэхийг түмний өмнө тангараглана. Хэрэв зөрчих аваас ард бүхэнд жигшигдэн Хувьсгалт улаан цэргийн цаазанд үл хэтрүүлсүгэй" гэжээ.

Үүнээс хойш дайчин бүр эх орондоо тангараг өргөдөг болсон ба өөр өөрийн онцлог, хөгжил, шинж чанартайгаар их бага янз бүрийн хэмжээнд нийт 11 удаа өөрчлөгдөн шинэчлэгдэж, цэргийн алба хаагч нэг бүрийн биелүүлбэл зохих эрхэм үүрэг болгон 1922, 1930, 1933, 1938, 1941, 1954, 1977, 1990, 1992" онд өөрчлөгдөж байжээ. 1941 оноос эхлэн нэгтгэл, ангиудын байлдагч бүр цэргийн тангаргийг биечлэн уншиж, эцэст нь гарын үсэг зуран тэрхүү гарын үсэг зурсан тангаргийг цэргийн алба хаасан тухай хувийн хэрэгт нь хавсаргадаг болсон түүхтэй.

<sup>1</sup>Хорин наймт тайлбар толь 1994. т.

<sup>2</sup>Эх орноо хамгаалах ариун үүрэг. УБ., 1981. т 30

<sup>3</sup>Монгол ардын үндэсний хувьсгалт цэргийн агуу хөгжилтийн товч зам. УБ., т 454-455

Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн тэргүүн ахлагч Б.НЯМБАЯР


ЦАХИМ ШҮҮДАНД

АЛБА ХААГЧИЙН АР ТЭРЭЭС ТАХАРХЛЫН ЗАХИА ХҮМЭЭН АВЧЭЭ

Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Дэлхий нийтийг хамраад байгаа цар тахлын халдварын нөхцөл буурахгүй байгаатай холбогдуулан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат албаны дайчдын эрүүл, аюулгүй байдлыг нь хангах хүрээнд ар гэрийнхэнтэй нь уулзуулах боломжгүй байгаа билээ. Үүнтэй уялдуулан Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран уулзалтыг утсан холбоо болон интернэтээр зохион байгуулснаас гадна 2020 онд Завхан аймгаас татагдан ирсэн дайчдын эцэг, эхийн дунд цэргийн алба хааж буй хүдээ хаягласан захидал, илгээмж явуулах ажлыг өрнүүлэв. Улмаар Завхан аймгийн Улиастай сумын харьяат байлдагч О.Наранбаатарын аав, бэлтгэл ахмад У.Отгонбаяр, ээж А.Нямсүрэн нарын эцэг эхчүүдээс "Ховдын цэнхэр хязгаарт аавынхаа мэргэжлээр алба хааж байгаа хүүгээрээ бахархаж байна" гэсэн талархлын захидлыг тус ангийн хамт олон хүлээн авсан байна.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ



МЭРТЭЖИЛ БҮХЭН САЙХАН



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Танкийн батальоны хугацаат цэргийн алба хаагчдын дунд энэ сарын 12-17-ны өдрүүдэд тусгай төлөвлөгөөний дагуу "Мэргэжил бүхэн сайхан" сэдэвт цогцолбор буухиа тэмцээнийг явууллаа.

Алба хаагчид ээмшиж буй мэргэжлээ бусдадаа сурталчлан таниулж, төгөл бүрийн дасгал, нормативуудыг багаараа цогцолбор байдлаар гүйцэтгэж уралдсан нь энэхүү тэмцээний нэгэн онцлог байсан юм. Цогцолбор тэмцээний "Шилдэг экипаж" буухиа төрөлд дэд түрүүч Д.Сүхбат ахлагчтай баг, "Бүлгийн марш" буухиа төрөлд байлдагч Н.Мөрөн ахлагчтай баг, "Бидний мэргэжил-Бидний бахархал" буухиа төрөлд дэд түрүүч Б.Бямбадорж ахлагчтай баг тэргүүлж, өргөмжлөл үнэ бүхий зүйлсээр шагнууллаа.

ХАМТДАА ХИЧЭЭЖ, ХАМТДАА ДАВЬЯ



Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Тус ангийн бие бүрэлдэхүүн "Ковид-19" цар тахлын эсрэг тэргүүн шугамд тэмцэж байгаа Цэргийн төв эмнэлэгийн удирдлага, эмч, сувилагч, ажилтан алба хаагчдад сэтгэлийн талархлыг уламжлав. Тэд нийгмийн хариуцлагын хүрээнд сайн үйлсийн аян зохион байгуулж сэтгэлийн хандив болгон "YUWELL 9F-3AW" загварын 5 литрийн зөөврийн хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч аппарат, 10 литрийн хүчилтөрөгчийн 2 баллоны хамт Цэргийн төв эмнэлгийн удирдлагад өгчдөр хүлээлгэн өглөө. Энэ үеэр ангийн захирагч хэлсэн үгэндээ "Цар тахлын хүнд нөхцөлд хоёргүй сэтгэлээр ажиллаж буй хос тангарагтай алба хаагчид болон арын албанд нь сэтгэл зүйгээр нь дэмжиж байгаа гэр бүлд талархан эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөж, энэхүү хүчилтөрөгчийн тоног төхөөрөмж нь эрүүл энхийн төлөө ариун үйлсэд нь нэмэр болж "Ковид-19" өвчнөөр халдварласан иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, хүндрэлийг багасгахад тус болно гэж итгэж байна. Хамтдаа хичээж, хамтдаа давья" гэсэн юм.

Ахлах дэслэгч Г.БИЛГҮҮТЭЙ